

**ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХЖЛИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ, САНХҮҮГИЙН  
ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ**  
(Мэдээлэл лавлагаа)

Г.Алтан-Оч

**Судалсан байдал**

Энэхүү бичвэрт өөрөөр заагаагүй бол доорх эх сурвалж буюу цахим хуудсыг ашигласан. Үүнд:

1. Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албаны дарга Х.Бум-Эрдэнийн “Мэдээлэл хүргүүлэх тухай” 2014.02.04-ний өдрийн 3/673 тоот албан бичиг;
2. Монголбанкны тэргүүн дэд дарга Б. Жавхлангийн 2014.03.05-ны өдрийн А-1<sup>а</sup>/254 тоот албан бичгийн хавсралт “Гадаад улсын банк, түүний нэгжийн үйл ажиллагааны зохицуулалтын талаар” мэдээлэл;
3. Монголбанкны судалгааны ажил, Товхимол 1-8, 2002-2014 <http://mongolbank.mn/listpublications.aspx?did=5> ;
4. Г.Алтан-Оч “Герман улсын хууль тогтоомж, эрхзүйн орчинд гадаадын хөрөнгө оруулалтын хувь хэмжээг хязгаарлах талаарх харьцуулсан судалгаа” УИХТГ 2009 он;
5. Г.Алтан-Оч, Ц.Элбэгзаяа “Хөрөнгө оруулалтын шингээх чадвар, түүнд нөлөөлөх хүчин зүйлс” УИХТГ 2013 он.

Уг судалгааны бичвэрт захиалгчийн доорх гурван асуудлын хүрээнд судалгаа, лавлагаа мэдээллийг багтаасан болно. Үүнд:

1. Нийгэм, эдийн засгийн өндөр хөгжилтэй улс орнуудын санхүүгийн зах зээлд гадаад улсын банк, санхүүгийн байгууллагуудын оролцоо, түүний эерэг, сөрөг нийтлэг үр дагаврууд;
2. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гадаадын банк, санхүүгийн байгууллагуудад Монгол Улсын санхүүгийн зах зээлд ажиллах зөвшөөрөл олговол гарч болох эерэг, сөрөг үр нөлөө;
3. Монгол Улсын банкны салбарт цөөн тооны оролцогчийн хэт давамгайл байдал үүсч болох эрсдэл байгаа эсэх, үүнээс иргэд аж ахуйн нэгжийн эрх ашгийг хамгаалах арга хэрэгслүүд.

**Нэг. Нийгэм, эдийн засгийн өндөр хөгжилтэй улс орнуудын санхүүгийн зах зээлд гадаад улсын банк, санхүүгийн байгууллагуудын оролцоо, түүний эерэг, сөрөг нийтлэг үр дагавруудын талаар**

Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг шингээх чадварт эергээр нөлөөлдөг чухал хүчин зүйлсийн нэг бол санхүүгийн зах зээлийн хөгжлийн түвшин буюу түүний сайн тогтолцоо юм.[5]

Цаашилбал, томоохон хөрөнгө оруулалтын сангууд хөгжиж буй улс орнуудын өндөр өгөөжтэй салбарт хил дамнан хөрөнгө оруулалт хийдэг ба ингэснээр тухайн бодит салбарт ажлын байр шинээр бий болгох, улс орны дундаж давхаргыг бэхжүүлэх зэрэг нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой.[1]

Дэлхийн улс орнуудын туршлага болон олон улсад хийгдсэн (Олон улсын валютын сан, Дэлхийн банк, Америкийн хөгжлийн банк) судалгаанаас үзэхэд, санхүүгийн зах зээл сайн хөгжсөн улс орнуудын хувьд гадаадын банк санхүүгийн байгууллагыг өөрийн улсын санхүүгийн салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох нь дараах эерэг үр дагавартай гэж үздэг.[2] Үүнд:

- Өрсөлдөөнийг дэмжих замаар үр ашгийг нэмэгдүүлэх;
- Зээлийн хүүг бууруулан зардлыг багасгах;
- Санхүүгийн зах зээлийг гэнэтийн цочролд өртөхөөс хамгаалж, санхүүгийн тогтвортой байдалд эергээр нөлөөлөх;
- Дотоодын зах зээлд шинэ техник, технологи нэвтрүүлэх;
- Өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх, хяналт болон эрсдлийн удирдлагын үр дүнд дотоодын зах зээлийн үр ашиг нэмэгдэж, эдийн засгийн өсөлтөд шууд нөлөөлөх;
- Гадаадын хөрөнгө оруулалтыг татах г.м.

Гэвч дээрх эерэг үр дагаврын зэрэгцээ дотоодын банкуудын зах зээлийг булаан эзлэх, тэдний багцын эрсдлийг нэмэгдүүлэх, гадаадын банк, санхүүгийн байгууллагын харьяалагдах улсын эдийн засгийн мөчлөгөөс хамааралтай болох г.м. сул талтай.[2]

Иймээс бодлого боловсруулагчид дотоодын эдийн засгийн тогтвортой байдлыг хангах үүднээс өөрийн санхүүгийн зах зээлд оролцогч гадаадын банк, санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанаас гарч болох эерэг болон сөрөг үр дагаврууд цэгнэн үнэлж, тэдгээрийн оролцооны түвшинг нарийн тогтоож, тодорхой хүрээнд хязгаарлах шаардлагатайг олон улсын шинжээчид анхааруулдаг.[2]

Тухайлбал, Герман улсад гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээг хуулиар хязгаарласан байдаг. Үүнд: Гадаадын хөрөнгө оруулалтын хувь хэмжээ компанийн нийт хөрөнгийн 10%-иас, компанийн тусгай хөрөнгийн 30%-иас хэтрэхгүй байхаар зохицуулагдсан бол харин Герман улсын хуулийн этгээд гадаадын хөрөнгө оруулалтын санд 25%-иас илүү хувь нийлүүлж болохгүй. Харин мөнгө угаахтай тэмцэхэд хамтарч ажилладаггүй улс орны санд хөрөнгө оруулахыг бүр хориглодог.[4]

Түүнчлэн зарим судлаачдын үзсэнээр, гадаадын банк, санхүүгийн байгууллага нь дотоодын санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж буй банкыг худалдан авсанаас өөрийн салбар буюу охин компанийг шинээр нээн ажиллуулах нь илүү үр ашигтай гэж дүгнэсэн байдаг.[2]

### **Хоёр. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гадаадын банк, санхүүгийн байгууллагуудад Монгол Улсын санхүүгийн зах зээлд ажиллах зөвшөөрөл олговол гарч болох зэрэг, сөрөг үр нөлөөний талаар**

Олон улсын хөгжлийн туршлагаас үзэхэд, санхүүгийн зах зээлийн хөгжил удааширч, санхүүгийн нөөц оновчгүй, үр ашиггүй хуваарилагдах болсон шалтгааныг доорх гурван үндсэн нөхцөл бүрдээгүйтэй холбон тодорхойлдог.[1] Үүнд:

- Санхүүгийн зуучлагчдын чадамж;
- Мэдээллийн ил тод байдал;
- Хөрөнгийн харилцан хөрвөх чадвар.

Манай орны санхүүгийн зах зээлд дээрх гурван шалтгаан, нөхцөл өнөөдөр нэгэнт бүрэлдэн тогтсон учир гадаадын банк, санхүүгийн байгууллагыг дотоодын санхүүгийн зах зээлд оруулах нь эерэг үр нөлөө үзүүлэх боломжтой юм.[1]

Мөн олон улсын томоохон санхүүгийн байгууллага нь манай үнэт цаасны зах зээлийн огцом хөгжилд түлхэц өгч, гадаадын хөрөнгө оруулагчдын эдийн засгийн сонирхлын чиг хандлагыг идэвхжүүлэн тэдгээрийг татах замаар олон улсын тавцанд Монгол Улсын нэр хүндийг өсгөх, цаашилбал, бүс нутгийн интеграцчилсан хөгжилд мөр зэрэгцэн орших боломж бүрдэнэ. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн өсөлтөд хувь нэмэр оруулах боломж байна.[1]

Монгол Улсын Банкны тухай хуулийн 22-р зүйлийг үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны А/80 дугаар тушаалаар баталсан “Банкны зөвшөөрлийн журам”-ыг боловсруулахдаа гадаадын банк, түүний нэгж Монгол Улсад банкны үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд учирч болзошгүй эрсдэл, эерэг болон сөрөг талуудыг нягталж, олон улсын туршлагыг судалж, түүнд тавигдах шаардлага, шалгуурыг бий болгосон.[2] Үүнд:

1. Сүүлийн 5 жилд активын хэмжээгээр дэлхийд эхний 150 банкинд багтсан байх;
2. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зэрэглэл тогтоодог байгууллагын “А”-гаас доошгүй үнэлгээ авсан байх;
3. Гадаадын бусад оронд 3-аас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх;
4. Монгол Улсад 1-ээс доошгүй жил банкны төлөөлөгчийн газраа байгуулж, үйл ажиллагаа явуулж байгаа;
5. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд оролцож байгаагүй г.м.

Түүнчлэн эдийн засгийн аюулгүй байдал болон санхүү, банкны салбарын тогтолцооны тогтвортой байдалд сөрөг нөлөөтэй гэж үзвэл, Монголбанк нь банк байгуулах, банкны хувьцаа эзэмших зөвшөөрөл олгохоос татгалзах эрхтэй байхаар журамласан.[2]

Гадаадын банк нь Монгол Улсад охин компанийн хэлбэрээр (хуулийн этгээдийн статустайгаар) банк байгуулах эрхзүйн орчныг бүрдүүлж байгаатай уялдуулан гадаадын банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг холбогдох хууль, олон улсын туршлагыг үндэслэн нөлөөлөх хүчин зүйлсийг харгалзан үзэж, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны А/81 дүгээр тушаалаар 65.0 тэрбум ₮ байхаар тогтоосон.[2]

Хэдийгээр гадаадын банк дотоодын зах зээлд орж ирсэнээр бага хүүтэй, урт хугацаатай зээлээр төслүүдийг санхүүжүүлэх боломжтой боловч өрсөлдөөний давамгайл байдал үүсгэж, дотоодын санхүүгийн тогтолцоонд сөргөөр нөлөөлж болзошгүй учир гадаадын банкны охин компанийг дотоод зах зээлд оруулахдаа тэдгээрийн техник, технологийн дэвшлийг ашиглах, шинэ үйлчилгээ, бүтээгдэхүүн нэвтрүүлэх, зөвхөн тухайн бүтээгдэхүүний зах зээлд оруулахаар хязгаарлах боломжтой юм. Жишээ нь, төслийн буюу бөөний болон худалдааны зээлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээ болон дотоодын банкуудын үйл ажиллагааны хязгаарлагдмал байгаа чиглэлээр зөвшөөрөл олгоно.[2]

Гадаадын санхүүгийн байгууллагад Монгол Улсад банкны үйл ажиллагаа явуулах эрх олгохдоо, мэдлэг, ур чадварыг шингээж, дотоодын боловсон хүчинд шилжүүлэн авахын тулд түүнийг дотоодын аж ахуйн нэгжтэй хамтрах талыг аль болох дэмжих нь зүйтэй. Учир нь гадаадын хөрөнгө оруулалт орж ирсэн шигээ эргэн гарах боломжтой. Мөн дотоод болон гадаад аж ахуйн нэгжүүдэд ижил боломж нөхцөл бүрдүүлэх нь чухал.[1]

Манай санхүүгийн зах зээлд 2008 оноос эхлэн гадаадын банк “Төлөөлөгчийн газар” байгуулан үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд 2014 оны 2 дугаарын байдлаар 5 банк Монголбанкнаас дээрх үйл ажиллагаа явуулах зөвшөөрлөө аваад байна.[2] Үүнд:

1. ING Bank N.V. 2008/8;
2. Standard Chartered Bank, 2012/7;
3. Bank of China, 2012/12;
4. Sumitomo Mitsui Banking Corporation, 2013/7;
5. Bank of Tokyo Mitsubishi UFJ, 2013/12.

**Гурав. Монгол Улсын банкны салбарт цөөн тооны оролцогчийн хэт давамгайл байдал үүсч болох эрсдэл байгаа эсэх, үүнээс иргэд аж ахуйн нэгжийн эрх ашгийг хамгаалах арга хэрэгслүүдийн талаар**

Монгол Улсын санхүүгийн зах зээл дэх өрсөлдөөний хэлбэрт нь олигополь шинжийг агуулсан Курногийн тэнцвэр нэгэнт тогтоод байна. Дотоод санхүүгийн зах зээлд олон улсад

хүлээн зөвшөөрөгдсөн гадаадын хөрөнгө оруулалттай банк, санхүүгийн байгууллагыг оролцуулах нь санхүүгийн хувьд хязгаарлагдмал, цөөн тооны оролцогчийн хэт давамгай байдлыг задалж, иргэд аж ахуйн нэгжийн эрэлт хэрэгцээнд нийцсэн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ. Ингэснээр зах зээлийн эрсдэл болон зээлийн хүүгийн хэмжээг бууруулах эерэг талтай.[1]

Нөгөөтэйгүүр, дотоодын банкуудын төлбөрийн чадварын бодит байдал, эрсдэл даах чадварын байдлаас шалтгаалан нэр хүндтэй том банк, санхүүгийн байгууллагад өөрийн орны санхүүгийн байгууллагаас илүүтэйгээр итгэх хандлага бий болох талтай. Улмаар ашиг орлого сайтай ч гадаадын шууд хөрөнгө оруулалт авч чаддаггүй иргэд, аж ахуйн нэгж нь гадны банкуудаар үйлчлүүлэн гадны банкуудын шаардлага хангахгүй хэсэг нь дотоодын банк санхүүгийн байгууллагад үлдэх эрсдэлтэй. Мөн дотоодын банкууд хүүгээ бууруулан улмаар илүү үр ашигтай өрсөлдөнө гэж үзэхэд, банкны салбарын эрэлт үнийн мэдрэмж багатай байдгийг харгалзан үзэх шаардлагатай.[1]

Иргэд, аж ахуйн нэгжийг санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг авахад тааламжтай нөхцөлийг бий болгох үүднээс гадаадын банк, санхүүгийн байгууллагад дотоодын санхүүгийн зах зээлд тодорхой хязгаарлалттай (харилцах, хадгаламж татахгүй, зөвхөн урт хугацаат хөрөнгө оруулалтын зээлийн санхүүжилт олгуулах г.м.) үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олговол эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлж, зээлийн хүү буурах, техник технологийн дэвшлийг бий болгох зэрэг эерэг нөлөөлөл үзүүлэх боломжтой гэж үзэж байна.[2]

Монгол Улсын иргэд, аж ахуйн нэгжийн эрх ашгийг хамгаалах харилцаа нь тухайн сахнуугийн байгууллагын үйл ажиллагааг хянах, санхүүгийн зах зээлийн мэргэжлийн зуучлагчдын үйл ажиллагааны зохистой байдлыг төлөвшүүлэх, тэдгээрийн үйл ажиллагаанд шударга, зүй зохистой ажиллагааны стандартыг хэвшүүлэх, дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцох, зах зээл урвуулан ашиглах болон бусад шударга бус гэмт үйлдэлтэй тэмцэх хууль, эрхзүйн хэм хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд оршино. Үүнийг ажил хэрэг болгоход олон улсын зарчмыг удирдлага болгон гадаадын зохицуулагч байгууллагатай мэдээлэл солилцоо болон харилцан туслалцааны тогтолцоог бүрдүүлэх үндсэн дээр тулгуурлах юм.[1]

Гадаадын хөрөнгө оруулалтыг төрийн бодлогын хувьд дэмжин ажиллах нь зүйтэй хэдий ч санхүүгийн зах зээл дэх дотоодын байгууллагуудын давуу тал, өрсөлдөөний оновчтой хувилбарыг сонгох, дотоодын зах зээлээ хамгаалах, төрөөс хяналт зохицуулалтын бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэх, оролцох шаардлага гарсан үед нь тухай бүр хамгаалалтын арга хэмжээ авах боломжтой байх нөхцөлийг бүрдүүлсэн байх нь зүйтэй.[1]

Банкуудын зээл, хадгаламжийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нөхцөл, шимтгэл, хураамжийн хэмжээг олон нийтэд тодорхой болгох, харилцагчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А-236 дугаар тушаалаар баталсан “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлыг хангуулах журам”-ын дагуу Монголбанкны цахим хуудсанд банкуудын ижил төстэй бүтээгдэхүүн, үйлчилгээний ерөнхий нөхцөл, хүү, шимтгэлийн мэдээллийг байрлуулах, олон улсад түгээмэл хэрэглэдэг зээлийн бодит өртөг тооцох аргачлал, түүнийг хэрхэн ашиглах зарчмыг тодорхойлох зэргийг зохицуулахаар болж байна. Тус журмыг мөрдөж эхэлснээр харилцагч санхүүгийн бүтээгдэхүүнийг оновчтой сонгох, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, шударга бус өрсөлдөөнийг хязгаарлах бололцоо бүрдэх юм.[2]#